# ГАРЧИГ

***НЭГ. 2025 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .. 4***

***ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 6***

***ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 11***

***ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 12***

***ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 12***

***ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 12***

***ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 13***

***НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 24***

***ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ........ 28***

***АРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 31***

***АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 39***

***ДҮГНЭЛТ ........ 39***

## ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

*Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт*....................................6
*Хүснэгт 2. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт*.............................13
*Хүснэгт 3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*................................24
*Хүснэгт 4. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний биелэлт*.31

## ЗУРГИЙН ГАРЧИГ

*Зураг 1. Төслийн байршлын зураг*....................................................................................4
*Зураг 2. Зам усалгаа хийж байгаа нь*................................................................................8
*Зураг 3. Ус ашиглах гэрээ*...............................................................................................9
*Зураг 4. Ус ашиглах гэрээ*...............................................................................................10
*Зураг 5. "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд тарих модны төлбөр төлсөн баримт*.......................................................................................................................11
*Зураг 6. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн хүрээнд хийгдсэн ойжуулалтын ажлын зардал төлсөн баримт*..............................................................................................12
*Зураг 7. Уурхайн талбай дахь галын булан*.......................................................................13
*Зураг 8. Галын хор, галын булан байгуулах ажлын төлбөрийн баримт*..........................14
*Зураг 9. Өрөмдлөг тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ*......................................................15
*Зураг 10. Өрөмдлөг тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ*....................................................16
*Зураг 11. Өрөмдлөг тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ*....................................................17
*Зураг 12. Өрөмдлөг тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ*....................................................18
*Зураг 13. Өрөмдлөг тэсэлгээний ажлын төлбөр төлсөн баримт*......................................19
*Зураг 14. Өрөмдлөг тэсэлгээний ажлын төлбөр төлсөн баримт*......................................20
*Зураг 15. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас*.......................21
*Зураг 16. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудас*.....................................22
*Зураг 17. Ил уурхайн тэсэлгээний ажлын паспорт*............................................................23
*Зураг 18. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт*.................................................................24
*Зураг 19. Хог хаягдал ачиж тээвэрлэх, хамтран ажиллах гэрээ*.......................................25
*Зураг 20. Хог хаягдал ачиж тээвэрлэх, хамтран ажиллах гэрээ*.......................................26
*Зураг 21. Хог хаягдал ачиж тээвэрлэх, хамтран ажиллах гэрээ*.......................................27
*Зураг 22. Агаарын чанарын шинжилгээний хариу*.............................................................28
*Зураг 23. Хөрсний шинжилгээний хариу*.............................................................................29
*Зураг 24. Усны шинжилгээний хариу*..................................................................................30
*Зураг 25. ОХШХ-ийн төлбөр төлсөн баримт*......................................................................31

*Зураг 26. Нийгмийн хариуцлагын гэрээ......................................................................32*
*Зураг 27. Нийгмийн хариуцлагын гэрээ......................................................................33*
*Зураг 28. Нийгмийн хариуцлагын гэрээ......................................................................34*
*Зураг 29. Нийгмийн хариуцлагын гэрээ......................................................................35*
*Зураг 30. ХАБЭА-н сургалтын сертификат ...............................................................36*
*Зураг 31. ХАБЭА-н сургалтын төлбөр төлсөн баримт..............................................37*
*Зураг 32. ХХАА-ны хувцас хэрэгслээр хангасан байдал..........................................38*
*Зураг 33. Ажилчдын хувцас хэрэгсэл худалдан авсан санхүүгийн баримт ......................38*

## НЭГ. 2025 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| ***Төслийн нэр:*** | “Асгат-Уул” нэртэй шохойн чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл |
| ***Төсөл хэрэгжүүлэгч:*** | “СИ БИ ЗИ” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 1911013037, Регистрийн дугаар: 2076624, Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл: MV-007746 |
| ***Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:*** | Дархан-Уул аймаг, Дархан сум, 6-р баг, 65-р байр-өөрийн байр. Утас: 9905-3180 |

***Төслийн байршил:*** Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг, “Силикат” ХК-ны төв байрнаас зүүн хойд зүгт 10 км зайд дэд бүтэц зам харилцаа сайн хөгжсөн дүүрэгт оршдог.

Талбайн солбицлын цэгүүд:

1. 49° 27’ 01.93” 106° 03’ 11.24”
2. 49° 27’ 01.93” 106° 02’ 41.23”
3. 49° 27’ 16.93” 106° 02’ 41.23”
4. 49° 27’ 16.93” 106° 03’ 11.24”




*Зураг 1. Төслийн байршлын зураг*

2025 онд уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу 2.3 мян.$м^3$ хөрс хуулж, 4.5 мян.$м^3$ шохойн чулуу олборлож “Силикат” ХК-ийн хөнгөн блокны үйлдвэрт нийлүүлсэн болно.

# ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт*

| Болзошгүй сөрөг нөлөөллүүд | Нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Хугацаа ба давтамж | Зардал, мян.төг | Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|---|---|
| **Агаар орчин** | | | | |
| **Уурхай орчимд тоосжилт үүсэх** | Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах | Үйл ажиллагааны турш | Үйл ажиллагааны зардлаас | Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн. /Фото зураг болон төлбөрийн баримтыг хавсаргав./ |
| | Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх | Жилд 2 удаа | ОХШХ-ийн зардлаас | ОХШХ-ийн дагуу хяналт шинжилгээг хийлгэсэн. |
| **Гадаргын ба газрын доорхи усны нөөц** | | | | |
| **Ашиглаж буй усны чанар муудах, хүрэлцээ бага байх** | Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь тогтмол хугацаанд төлөх | Үйл ажиллагааны турш | Үйл ажиллагааны зардлаас | Ус ашигласны төлбөрийг гэрээний дагуу хугацаанд нь төлсөн |
| | Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх | Улиралд 1 удаа | Үйл ажиллагааны зардлаас | ОХШХ-ийн хүрээнд шинжилгээ хийлгэсэн. |
| **Газрын гадарга, хэвлий** | | | | |
| **Шохойн чулуу олборлосоноор газрын хэвлийд хоосон орон зай шинээр үүсгэнэ.** | Уурхайн малталтууд болон олборлосон орон зайд бэхэлгээ, хамгаалалтын цул зэргийг үлдээж нуралт үүсэхээс сэргийлнэ | Уурхай ашиглалтын төгсгөлд | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан зардлаар | Энэ онд нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй болно. |
| **Хөрсөн бүрхэвч** | | | | |
| **Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс овоолго, уурхайн тосгон, бусад байгууламжуудын дор дарагдаж, элэгдэл, эвдрэлд өртөнө.** | Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулахын өмнө өнгөн хөрсийг хуулан авах, | Ашиглалтын явцад | Үйл ажиллагааны зардлаас | Шимт хөрсний овоолго үүсгэн хадгалсан. Энэ онд нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй болно. |
| | Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах | | | |
| **Уурхайн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох** | Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх | Ашиглалтын явцад | - | Уурхайн зам талбайг тогтмол услан чийгшүүлж, зам арчилгаар тогтмол хийж гүйцэтгэсэн. |
| **Ургамлан нөмрөг** | | | | |
| **“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх** | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 100 ш мод тарих | Ашиглалтын явцад | Үйл ажиллагааны зардлаас | “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тарих модыг “Зулзагын ой” хөтөлбөрт тарихаар төлөвлөж, зардлыг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | тушаасан болно. /Төлбөрийн баримтыг хавсаргав./ |
| **Амьтны аймаг** | | | | |
| **Амьтны аймагт хохирол учруулах, тоо толгой хорогдох, идэш тэжээлийн хомсдол үүсэх** | Мал амьтан өнгөрч гардаг хэсгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, Авто машины хурдыг тогтоосон хязгаарт байлгах | Ашиглалтын явцад | Үйл ажиллагааны зардлаас | Уурхайн тээврийн зам дагуу тэмдэг, тэмдэглэгээ байрлуулсан. |

Уурхайн тоосжилтыг бууруулах зорилгоор гол замыг чийгшүүлэх, услах ажлыг дулааны улирлын хуурайшилттай үед тогтмол зохион байгуулж ажилласан. Уг ажлын зардалд 160.0 мян.төг зарцуулсан болно.



***Зураг 2. Зам усалгаа хийж байгаа нь***

БАТЛАВ:
"ДАРХАН УС СУВАГ" ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ҮҮРГИЙГ ТҮР ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ
ДЭД ЗАХИРАЛ, ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
Т.БУЯНДЭЛГЭР

БАТЛАВ:
"СИ БИ ЗИ " ХХК-ИЙН
ЗАХИРАЛ В.МӨНХТУЯА

**УС АШИГЛАХ ГЭРЭЭ**

2024.11.21 №2024/207 Дархан Уул аймаг

Нэг талаас "Дархан Ус суваг" ХК-ийг (цаашид "А" тал буюу нийлүүлэгч гэх ) түүнийг төлөөлж УХА-ны дарга Ц.Зол-Эрдэнэ, нөгөө талаас "Си би зи" ХХК-ийн захирал В.Мөнхтуяа РД:2076624 (цаашид "Б" тал буюу захиалагч гэх) нар Монгол Улсын Иргэний хуулийн 476 дугаар зүйлийг удирдлага болгон дараах гэрээг харилцан тохиролцож байгуулав.

**1. Нийтлэг заалт**

1.1. Ахуйн болон ундны хэрэглээний ус захиалан авч ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

**2. Гэрээний хугацаа**

2.1. Гэрээний ерөнхий хугацаа 2024 оны 11 сарын 21-ний өдрөөс эхлэн 2025 оны 11 сарын 21-ний өдөр дуусах хүртэл хугацаатай байна.

**3. Гэрээний үнэ, төлбөр төлөх нөхцөл**

3.1. Нэг литр усыг 6 /зургаан/ төгрөгөөр тооцож төлбөр тооцоо хийгдэнэ.
3.2. Төлбөрийг компанийн ХААН банкны 5045052676 тоот дансанд шилжүүлнэ.

**4. А талын эрх, үүрэг**

4.1.Цэвэр усыг Б тал буюу захиалагчийн захиалсан хэмжээгээр саадгүй нийлүүлнэ.

4.2. Нийлүүлсэн усны хэмжээ тоолуурын заалтыг бүртгэж тооцоо нийлж ажиллана.

**5. Б талын эрх, үүрэг**

5.1. Б тал цэвэр усыг "Дархан-Ус суваг" ХК-ийн машин худгаас өөрийн усны машинаар авч хэрэглэнэ.
5.2.Гэрээнд заагдсан үнээр литр тутмын төлбөрийг нийлүүлэгчийн дансанд урьдчилан төлнө.

**6.Давагдашгүй хүчин зүйл**

6.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт , үер, гал түймэр, шуурга, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд урьдчилан мэдэгдэж байх.

*Зураг 3. Ус ашиглах гэрээ*

**7. Бусад заалт**

7.1. Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

7.2. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

7.3. Талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл Монгол Улсын иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу маргааныг А тал буюу нийлүүлэгчийн харьяаллын дагуух шүүхээр шийдвэрлүүлнэ

**8. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам**

8.1. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

8.2. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

**9. Талууд**

**Нийлүүлэгч:**

"Дархан-Ус суваг" ХК-ийг төлөөлж

УХА-ийн дарга

........................ Ц.Зол-Эрдэнэ

Ашиглалтын инженер

........................ Ж.Хишигжаргал

Хуулийн зөвлөх, гэрээний мэргэжилтэн

........................Ж.Нарандорж

Утас: 77003700

Хаяг: Дархан сум 8-р баг 17 хороолол өөрийн байранд

**Захиалагч:**

"Си би зи" ХХК-ийн захирал

........................ В.Мөнхтуяа

Утас: 99053180

Хаяг:Дархан-Уул аймаг, Дархан сум Үйлдвэрийн дүүрэг

*Зураг 4. Ус ашиглах гэрээ*

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээд 100 ш мод тарихаар төлөвлөсөн бөгөөд уурхайн талбай орчимд мод тарих тохиромжтой талбай байхгүй учраас аймгийн БОАЖГ-тай зөвшилцсөний дагуу “Зулзагын ойжуулалт” арга хэмжээнд нэгдэж, тухайн талбайд тарих модны мөнгийг 4-р сард шилжүүлсэн болно. /Төлбөрийн баримтыг хавсаргав./

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын/Journal No:001119721762

Системийн огноо/System Date:2025.04.30 10:26:46

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт/From | IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number 5086046007 | Нэр/Name B****Я МӨНХТУЯА | Дүн/Amount 5,000,000.00 MNT | Ханш/Rate 1.00 |
| / Таван сая төгрөг / | | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No 34 IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number 140801873061 | Банкны нэр/Bank Name State Bank - Төрийн банк Нэр/Name БАТБАДРАХ ДЭЛГЭР | 5,000,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
Зулзага ойжуулалт Си Би Зи ХХК 99053180

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

*Зураг 5. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тарих модны төлбөр төлсөн баримт*

## ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Асгат-Уул” шохойн чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн хувьд уул техникийн нөхцлөөс шалтгаалан нөхөн сэргээлт хийгдэх боломжгүй учир 2025 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй болно.

## ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд “Ногоон Дархан” хөтөлбөрт оролцохоор төлөвлөсөн бөгөөд аймгийн БОАЖГ-аас төлөвлөн хэрэгжүүлсэн “Зулзагын ойжуулалт” арга хэмжээнд нэгдэж, 5 000.0 мян.төг-ийг 10-р сард шилжүүлсэн болно. /Төлбөрийн баримтыг хавсаргав./



Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын/Journal No:001324947439

Системийн огноо/System Date:2025.10.28 13:44:30

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт/From | IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number 5086046007 | Нэр/Name В****Я МӨНХТУЯА | Дүн/Amount 3,200,000.00 MNT | Ханш/Rate 1.00 |
| / Гурван сая хоёр зуун мянган төгрөг / | | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No 34 IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number 140801873061 | Банкны нэр/Bank Name State Bank - Төрийн банк Нэр/Name БАТБАДРАХ ДЭЛГЭР | 3,200,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
Си Би Зи ХХК 2076624 Зулзага ойжуулалт

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers



Системийн огноо / System date: 2025.10.28

Журналын № / Journal №: 943290681002

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт | Дансны № / Account № MN870034140001875970 | Нэр Овог / Name Surname СИ БИ ЗИ | Мөнгөн дүн тоогоор / Amount 1,800,000.00 MNT | Ханш / Rate 1.00 |
| | Мөнгөн дүн үсгээр / Amount in words: / нэг сая найман зуун мянга-н төгрөг / | | | |
| Кт | Банкны № / Bank № Дансны № / Account №: MN240034140801873061 | Банкны нэр / Bank name Төрийн банк Нэр Овог / Name Surname БАТБАДРАХ ДЭЛГЭР | Мөнгөн дүн тоогоор / Amount 1,800,000.00 MNT | Ханш / Rate 1.00 |

Гүйлгээний утга / Details of payment:
Си Би Зи ХХК-с 2076624 Зулзага ойжуулалт

*Зураг 6. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн хүрээнд хийгдсэн ойжуулалтын ажлын зардал төлсөн баримт*

## ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээг уурхай хаагдах үед хаалтын зардалд тусгаж өгсөн тул 2025 оны БОМТ-нд энэ чиглэлийн үйл ажиллагаа төлөвлөгдөөгүй болно.

## ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“СИ БИ ЗИ” ХХК-ны тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна.

# ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 2. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Зардал | Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гал түймэр | Галын булан байрлуулах | Уурхайн тосгон | Ашиглалтын зардлаас | Уурхайд галын булан байрлуулсан |
| | | Аваар устгах төлөвлөгөө боловсруулах | Уурхай | | Аваар устгах төлөвлөгөө боловсруулан батлуулж, мөрдлөг болгон ажилласан. |
| 2 | Тэсрэх бодис | Мэргэжлийн гэрээт байгууллагаар тэсэлгээний ажил гүйцэтгүүлэх | Тэсэлгээний ажлын үед | | 2025 онд өрөмдлөг тэсэлгээний ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн болно. |
| | | Тэсрэх бодисын тоо бүртгэлийг тогтмол хийх | | | |
| | | Тэсрэх бодисын үлдэгдэл, сав баглаа боодлыг гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан аюулгүй болгох | | | |



***Зураг 7. Уурхайн талбай дахь галын булан***

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын/Journal No:11025480

Системийн огноо/System Date:2025.06.24 11:44:47

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт/From | IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card number<br>5309286971 | Нэр/Name<br>В****Я МӨНХТУЯА | Дүн/Amount<br>1,200,000.00 MNT | Ханш/Rate<br>1.00 |
| / Нэг сая хоёр зуун мянган төгрөг / | | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No<br>05<br>IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card Number<br>5045564050 | Банкны нэр/Bank Name<br>Khan Bank - Хаан банк<br>Нэр/Name<br>О*****Л ЛХАГВАЖАВ | 1,200,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
Галын хор анхан шатны тусламж үнэ

***Зураг 8. Галын хор, галын булан байгуулах ажлын төлбөрийн баримт***

**БАТЛАВ: "СИ БИ ЗИ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ**

**В.МӨНХТУЯА**

**БАТЛАВ: "ТИ ЭМ БИ ЭН " ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

**Я.ЛУВСАНДОРЖ**

**ӨРӨМДЛӨГ, ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ**

2023 оны 09 сарын 25-ны өдөр № 23/27 Улаанбаатар хот

Энэхүү гэрээг Монгол улсын Иргэний хуулийн 343-358 дугээр заалтуудыг үндэслэн:

Нэг талаас Дархан-уул аймгийн Дархан сум Улсын бүртгэлийн №1911013037, РД-2076624 тоот дугаартай "СИ БИ ЗИ" ХХК, түүнийг төлөөлж, Захирал албан тушаалтай В.Мөнхтуяа /цаашид "Захиалагч" гэх,

Нөгөө талаас Сүхбаатар дүүрэг 11-р хороо, ProOne 804 тоот Улсын бүртгэлийн №9011105119, РД-5147816 тоот дугаартай "ТИ ЭМ БИ ЭН " ХХК, түүнийг төлөөлж, Гүйцэтгэх захирал албан тушаалтай Я.Лувсандорж цаашид "гүйцэтгэгч" гэх, гэрээнд оролцогчдыг хамтад нь "талууд" гэх, харилцан тохиролцсоны үндсэн дээр дараах гэрээг байгуулав.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэ гэрээний зорилт нь Гүйцэтгэгч тал нь Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших "Асгат уул" нэртэй шохойн чулууны ил уурхайн тэсэлгээний ажил үйлчилгээг \цаашид тэсэлгээний ажил гүйцэтгэх гэх\ гүйцэтгэх, захиалагч тал ажил, үйлчилгээний төлбөр төлөхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.

1.2. Байршил: Дархан-уул аймгийн Хонгор сумын нутагт орших "Асгат уул" нэртэй шохойн чулууны ил уурхайн

1.3. Энэхүү гэрээ нь хоёр талын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болж, Талууд харилцан хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.

1.4. Доор дурьдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно. (цаашид "гэрээний баримт бичиг" гэх).

1.4.1. Компанийн гэрчилгээний хуулбар

1.4.2. Тусгай зөвшөөрлийн хуулбар

1.4.3. Холбогдох бусад баримт бичиг

1.5. Гэрээний хугацаа: Энэхүү гэрээний хугацаа нь 2023 оны 09 сарын 25-ны өдрөөс эхлэн 2023 оны 12 дугээр сарын 31-ний өдрийг хүртэл байна.

1.6. Нийт ажлын хэмжээ: Өрөмдөж бэлтгэсэн 80 шонгийн тэсэлгээний ажлыг хийж гүйцэтгэх

**ХОЁР. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

2.1. Гэрээт ажлын төлбөр: 30 000 000 /Гучин сая төгрөг/ НӨАТ орсон

2.2. Тэсэлгээний ажлын гэрээний үнийн дүнгийн 70 хувийг гэрээнд гарын үсэг зурагдсанаар гүйцэтгэгч талын Хас банкны 5002780549 тоот дансанд шилжүүлнэ. Үлдэгдэл 30 хувийн төлбөрийг тэсэлгээний ажил хийж гүйцэтгэсний дараагаар ажлын 3 хоногт багтаан шилжүүлнэ.

2.3. Хэрэв гүйцэтгэгч нь гэрээт ажлыг холбогдох шаардлага, дүрэм, журам, стандартын дагуу гүйцэтгээгүй бол Захиалагч тус ажлын төлбөрийг төлөх үүрэг хүлээхгүй.

*Зураг 9. Өрөмдлөг тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ*

2.4. Гүйцэтгэгчийн буруугаас үүдэн аливаа нэмэлт зардал /дутуу тэсэлгээ хийсэн доголдлыг арилгуулах, гэрээт ажлыг гүйцээн хийлгэхтэй холбоотой зардал, талууд тоо хэмжээн дээр маргаан гаргасан тохиолдолд гуравдагч этгээдээр тогтоолгох/-ыг гэрээний талбороос суутгана.

### ГУРАВ. АЖЛЫН ҮР ДҮНГ ХҮЛЭЭЛЦЭХ, БАТАЛГААТ ХУГАЦАА

3.1 Талууд тухайн блокын тэсэлгээний ажлыг хамтран нарийвчлан шалгаж, хоёр талын актаар баталгаажуулан хүлээн авна.

3.2 Гэрээт ажлын эцсийн үр дүнг талууд хамтран нарийвчлан шалгаж холбогдох хууль, журам шаардлагад бүрэн нийцсэн гэж үзсэн тохиолдолд хүлээлцэх бөгөөд Гүйцэтгэгч нь гүйцэтгэлийн тайланг бэлдэж, холбогдох баримт бичгийн хамт Захиалагчид хүлээлгэж өгнө.

3.3 Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажил нь Захиалагчийн болон холбогдох хууль, дүрэм, журам шаардлагад нийцээгүй, чанаргүй гүйцэтгэсэн нь эрх бүхий байгууллагын дүгнэлт болон бусад байдлаар илэрсэн бол Гүйцэтгэгч нь тухайн доголдлыг Захиалагчаас болон бусад байгууллагаас өгсөн хугацаанд үнэ төлбөргүй арилгах ба ийнхүү арилгах хуртэл Захиалагч гэрээний үүргээ биелүүлсэнд тооцохгүй бөгөөд энэ хугацааг Гүйцэтгэгч гэрээний хугацааг хэтрүүлсэнд тооцно.

### ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

**4.1 Захиалагчийн эрх, үүрэг**

4.1.1. Тэсэлгээний ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай бичиг баримтаар хангах үүрэгтэй.

4.1.2. Гүйцэтгэгчээс тэсэлгээний ажлыг хугацаандаа гүйцэтгэхэд хяналт тавих эрхтэй.

4.1.3. Тэсэлгээний ажлын талаар шаардлагатай мэдээ, баримтыг авах эрхтэй.

4.1.4. Тэсэлгээний ажлыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу гүйцэтгэхэд шаардлага тавих эрхтэй.

4.1.5. Гүйцэтгэгчийн чанар стандартын шаардлагын дагуу гүйцэтгэсэн ажлыг гэрээний дагуу хүлээн авах эрхтэй.

4.1.6. Өрөмдсөн цооногт тэсэлгээний бодисыг байрлуулах явцад хяналт тавих, шаардлагатай тохиолдолд санал болон тэсэлгээний бодисын санал өгөх эрхтэй.

4.1.7. Тэсэлгээний ажил гүйцэтгэсний дараа цаг тухайд нь сийрэгжсэн чулуулгийг тээвэрлэж зайлуулах үүрэгтэй.

4.1.8. Гэрээнд заасны дагуу ажлын хөлсийг төлнө.

4.1.9. Гүйцэтгэгч тал гэрээний заалтыг удаа дараа 2 ба түүнээс дээш зөрчсөн, гэрээний дагуу тавьсан шаардлагыг биелүүлээгүй, шаардлага хангахгүй ажил байна гэж үзсэн нөхцөлд Захиалагч тал гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлэх ба зөрчлийг арилгаагүй, талууд тохиролцоод хүрч чадаагүй тохиолдолд Захиалагч ажлыг зогсоож гэрээг цуцлаж, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх, тэсэлгээний ажлыг гуравдагч этгээдээр хийлгэх эрхтэй.

4.1.10. Захиалагч нь ажил хийгдэхээс өмнө гүйцэтгэгчийн тэсэлгээний ажлын паспорттай танилцаж, гарын үсэг зурж баталгаажуулна.

4.1.11. Тэсэлгээний ажлын үед тэсэлгээний аюултай бүсээс эд хөрөнгө /ажилчдын байр, цахилгааны шугам г.м/ тоног төхөөрөмжийг гаргаж чөлөөлөх, эрсдлээс хамгаалах үүрэгтэй.

**4.2. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

4.2.1. Гүйцэтгэгч нь тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн сонголтыг захиалагчтай хамтран шийдвэрлэх эрхтэй.

4.2.2. Гүйцэтгэгч тал нь захиалагчийн өрөмдөж бэлтгэсэн талбайн өрмийн паспорттай танилцаж, өрөмдлөгийн мэдээллийг бүрэн авч түүнд зарцуулах тэсрэх материалыг паспортоор бэлтгэн тэсэлгээний ажлыг гүйцэтгэх үүрэгтэй.

*Зураг 10. Өрөмдлөг тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ*

4.2.3. Захиалагч талаас төлбөрийг гэрээний дагуу төлөхийг шаардах эрхтэй.

4.2.4. Тэсэлгээний ажлын дараа баарсан цэнэг илэрвэл ажлыг зогсоож аюулгүй болгох арга хэмжээг тэсэлгээний ажлын удирдагчийн хяналтан дор явуулах үүрэгтэй.

4.2.5. Гүйцэтгэгч нь тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн чанар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр тэсэлгээ хийх үүрэгтэй.

4.2.6. Гүйцэтгэгч нь өрөмдлөг, тэсэлгээний ажил гүйцэтгэхтэй холбоотой баримт бичгийг бүрдүүлэн захиалагчид хүлээлгэн өгөх , гэрээт ажлыг биечлэн гүйцэтгэх үүрэгтэй.

4.2.7. Ажлын талбайд ажиллах хүчийг Гүйцэтгэгчээс 100% хариуцах үүрэгтэй.

4.2.8. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэх хугацаанд өөрийн ажилчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг бүрэн хариуцаж талбай дахь ажилчдын сахилга бат, дэг журам, зохион байгуулалтыг хангаж ажиллах ба аюулгүй ажиллагааны дагуу өөрийн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл (ажлын хувцас, каск, хамгаалалтын бүс, гутал, бээлий г.м )-ээр тогтмол бүрэн хангаж ажиллуулах, дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаатай холбоотой асуудал, үйлдвэрийн талбайд гарсан ослын хариуцлага, түүнтэй холбогдон гарсан нөхөн олговор, бусад зардлыг бүрэн хариуцахаас гадна бусад хууль, эрх зүйн актыг удирдлага болгон ажиллах үүрэгтэй.

4.2.9. Осол, гэмтэл, зам тээврийн осол болон гал түймрийн шалтгааныг урьдчилан бүрэн арилгах үүрэгтэй.

4.2.10. Гүйцэтгэгч нь уурхайд тэсэлгээний ажил гүйцэтгэх байршил, цаг хугацааг захиалагчтай хамтран урьдчилан төлөвлөнө.

4.2.11. Тэсэлгээний ажил бүрийн өмнө тухайн дэвсгэр нутгийн аюулгүй байдлыг хангасан талаар гүйцэтгэгч талаас зөвшөөрүүлсэний үндсэн дээр тэсэлгээний ажлыг хийж гүйцэтгэх үүрэгтэй.

4.2.12. Тэсэлгээ бүрт харуул гаргасны дараа тэсэлгээний ажлыг эхлэх үүрэгтэй.

4.2.13. Гүйцэтгэгч тэсрэх дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон Улсын гэрээ, конвенцыг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллах үүрэгтэй.

4.2.14. Ажлын үр дүнгийн доголдлыг арилгахад шаардагдах зардал /ажлын хөлс, материалын зардал, замын хураамж болон тээврийн хөлс гэх мэт/-ыг хариуцах үүрэгтэй.

4.2.15. Тэсэлгээх дайрганы блокоос гарах овор хэтэрсэн чулуулгийн хэмжээ нийт уулын цулын 5%-иас хэтрэхгүй, тэсэлсэн чулууны хэмжээ 50х50 см-ээс хэтрэхгүй байна. Овор хэтэрсэн чулуулгийг шаардагдах хэмжээнд бутлаж өгнө.

4.2.16. Гүйцэтгэгч нь уурхайд тэсэлгээний ажил хийж гүйцэтгэхэд гарсан аливаа материал, хог хаягдлыг өөрсдөө зайлуулж цэвэрлэх үүрэгтэй.

**ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА**

5.1. Талууд гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдох Монгол улсын хууль, дүрэм журмын хэм хэмжээг сахих үүрэг хүлээнэ.

5.2. Талууд өрөмдлөгийн захиалгын хуудас дээр цооногийн хоолойт ойртолтын зайг тэмдэглэж баталгаажуулна.

5.3. Гүйцэтгэгч тал Захиалагч талын өрөмдлөгийн паспортын дагуу төлөвлөсөн хугацаанд тэсэлгээ хийгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хоног тутамд 0,5 алданги тооцно.

5.4. Гүйцэтгэгч талаас гэрээнд заасан үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд Захиалагч талд ажлын 7 хоногийн өмнө албан тоотоор заавал мэдэгдэнэ. Мэдэгдээгүй улмаас гарсан аливаа төрлийн хохирлыг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

5.5. Давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан захиалагч талаас гэрээнд заасан хугацаанд тэсэлгээ

*Зураг 11. Өрөмдлөг тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ*



хийгдэх боломжгүй тохиолдолд захиалагч талд бичгээр мэдэгдэнэ.

5.6. Талууд өөрсдийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гарсан хохирлыг бие даан хариуцна.

5.7. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

5.8. Давтагдашгүй хүчин зүйлд тооцогдох гал түймэр, үер болон газар хөдлөх зэрэг байгалийн гамшиг үүсэн нөхцөлд энэхүү гэрээний үүргээс талууд хэсэгчлэн болон бүр мөсөн чөлөөлөгдөнө.

ЗУРГАА. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

6.1. Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад үүссэн аливаа маргаантай асуудлыг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба хэрэв ээ зүйтээр шийдвэрлэж чадаагүй нөхцөлд талууд Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.2. Гэрээг адил хүчинтэй 2 хувь үйлдэх бөгөөд талууд тус бүр нэг хувийг хадгална.

ДОЛОО. БУСАД

7.1. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулах бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

7.2. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

7.3. Гэрээг хугацаанаас өмнө цуцлах саналыг, санал гаргагч тал нөгөө талд 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

“Си Би Зи” ХХК-ийг төлөөлж: Захирал /В.Мөнхтуяа/

Хаяг:Монгол улс, Улаанбаатар хот

“ Ти Эм Би Эн ” ХХК-ийг төлөөлж: Гүйцэтгэх захирал /Я.Лувсандорж/

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг

11-р хороо, Премиум оффис 804 тоот

Утас/факс: 77224777, 99086751, 91997747

*Зураг 12. Өрөмдлөг тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ*

Огноо/Date:2025.06.27 14:45:57

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын/Journal No:001186762352

Системийн огноо/System Date:2025.06.27 14:45:57

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт/From | IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card number<br>5086046007 | Нэр/Name<br>B****Я МӨНХТУЯА | Дүн/Amount<br>5,000,000.00 MNT | Ханш/Rate<br>1.00 |
| / Таван сая төгрөг / | | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No<br>32<br>IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card Number<br>005002780549 | Банкны нэр/Bank Name<br>XACBANK - ХАСБАНК<br>Нэр/Name<br>ТИ ЭМ БИ ЭН ХХК | 5,000,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
Си Би Зи төлбөр тэсэлгээ

Огноо/Date:2025.06.27 14:45:04

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын/Journal No:001186761118

Системийн огноо/System Date:2025.06.27 14:45:04

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт/From | IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card number<br>5086046007 | Нэр/Name<br>B****Я МӨНХТУЯА | Дүн/Amount<br>5,000,000.00 MNT | Ханш/Rate<br>1.00 |
| / Таван сая төгрөг / | | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No<br>32<br>IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card Number<br>005002780549 | Банкны нэр/Bank Name<br>XACBANK - ХАСБАНК<br>Нэр/Name<br>ТИ ЭМ БИ ЭН ХХК | 5,000,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
Си БИ ЗИ тэсэлгээ төлбөр 2076624

Огноо/Date:2025.06.27 14:38:32

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын/Journal No:001186752250

Системийн огноо/System Date:2025.06.27 14:38:32

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт/From | IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card number<br>5086046007 | Нэр/Name<br>B****Я МӨНХТУЯА | Дүн/Amount<br>5,000,000.00 MNT | Ханш/Rate<br>1.00 |
| / Таван сая төгрөг / | | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No<br>32<br>IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card Number<br>005002780549 | Банкны нэр/Bank Name<br>XACBANK - ХАСБАНК<br>Нэр/Name<br>ТИ ЭМ БИ ЭН ХХК | 5,000,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
Си Би Зи тэсэлгээний төлбөр 2076624

***Зураг 13. Өрөмдлөг тэсэлгээний ажлын төлбөр төлсөн баримт***

Огноо/Date:2025.06.27 14:35:51

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын/Journal No:001186748770

Системийн огноо/System Date:2025.06.27 14:35:51

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт/From | IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card number<br>5086046007 | Нэр/Name<br>B****Я МӨНХТУЯА | Дүн/Amount<br>5,000,000.00 MNT | Ханш/Rate<br>1.00 |
| / Таван сая төгрөг / | | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No<br>32<br>IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card Number<br>005002780549 | Банкны нэр/Bank Name<br>XACBANK - ХАСБАНК<br>Нэр/Name<br>ТИ ЭМ БИ ЭН ХХК | 5,000,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
Си Би Зи ХХК тэсэлгээний төлбөр 2076624

Огноо/Date:2025.06.27 14:48:59

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын/Journal No:001186766350

Системийн огноо/System Date:2025.06.27 14:48:59

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт/From | IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card number<br>5086046007 | Нэр/Name<br>B****Я МӨНХТУЯА | Дүн/Amount<br>1,500,000.00 MNT | Ханш/Rate<br>1.00 |
| / Нэг сая таван зуун мянган төгрөг / | | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No<br>32<br>IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card Number<br>005002780549 | Банкны нэр/Bank Name<br>XACBANK - ХАСБАНК<br>Нэр/Name<br>ТИ ЭМ БИ ЭН ХХК | 1,500,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
Си Би Зи тэсэлгээ төлбөр 2076624

***Зураг 14. Өрөмдлөг тэсэлгээний ажлын төлбөр төлсөн баримт***

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

# УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
## ТЭСРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ АШИГЛАХ ХЯНАЛТЫН ХУУДАС 25/192

**Тэсэлгээний ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл:** ТИ ЭМ БИ ЭН ХХК, 2023.07.06, 888
**Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл:** СИ БИ ЗИ ХХК, MV-007746
**Тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээ:** 2025.06.12, BS - 25/09

**Төслийн баталгаажсан баримт бичиг:** Дархан-Уул аймгийн Хонгор сумын Асгат уул ордын 2025 оны уулын ажлын төлөвлөгөө

**Тэсэлгээний ажлын байршил, зориулалт:** Дархан-Уул аймгийн Хонгор сум, Асгат уул ил уурхайд

**Тэсрэх материалын хадгалалт:** Дархан-Уул аймгийн Хонгор сумын Асгат уул ил уурхайд өрөмдөж бэлтгэсэн цооногт шууд тэсэлнэ.

| № | *Тэсрэх материалын нэр* | *Хэмжих нэгж* | *Нийт хэмжээ* | |
|---|---|---|---|---|
| | | | *Тоо* | *Үсгээр* |
| 1 | Анфо | кг | 10400 | арван мянга дөрвөн зуу |
| 2 | Эмульс | кг | 2600 | хоёр мянга зургаан зуу |
| 3 | Цахилгаан бус тэслүүр /гадарга/ | ш | 600 | зургаан зуу |
| 4 | Цахилгаан бус тэслүүр /цооног/ | ш | 600 | зургаан зуу |
| 5 | Өдөөгч | ш | 600 | зургаан зуу |
| 6 | Цохилтын долгион дамжуулах гуурс /тэслүүртэй/ | м | 6000 | зургаан мянга |
| 7 | Цочир дамжуулах шижим | м | 3000 | гурван мянга |
| 8 | Гал дамжуулах шижим | м | 50 | тавь |
| 9 | Хором удаашруулагч | ш | 180 | нэг зуун ная |
| 10 | Бялт тэслүүр | ш | 30 | гуч |

Тэсэлгээний ажлыг инженер Н.Доржгарав, Б.Үүрийнцолмон удирдан, тэсэлгээчин М.Төгөлдөр, Э.Батбаасан, Б.Мөнх-Амьдрал, Б.Гантөгс нар "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-ийн заалтуудын дагуу аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, тэсэлгээний ажлыг явуулна.

**Онцгой нөхцөл:** Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн зарцуулалтад тавих дотоодын хяналтыг сайжруулах, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл авах бүр орон нутгийн цагдаагийн байгууллагад мэдэгдэж байна.

**Хүчинтэй хугацаа:** 2026.01.15

Салбарын улсын ерөнхий байцаагч Д.Даваадорж

**Хяналтын хуудас олгосон:**
Улсын ахлах байцаагч Ч.Мөнхсүрэн

**Хяналтын хуудас авсан:**
Ти Эм Би Эн ХХК-н менежер Н.Доржгарав

2025.06.17

**Дотоодын хяналтыг сайжруулцгаая!**

***Зураг 15. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас***

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

**ТЭСРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ ТЭЭВЭРЛЭХ ХУУДАС №25/192-957**

УУХҮЯ-аас олгосон тэсрэх материал ашиглах хяналтын хуудас: **№25/192**

ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төвийн олгосон маршрут: **2025.07.01, №25/1-1817**

Тэсэлгээний ажил гүйцэтгэгч: **Ти Эм Би Эн ХХК**

Тэсэлгээний ажил захиалагч: **Си Би Зи ХХК, Ил уурхай**

Тэсрэх материал олгох агуулах: **Дархан-Уул аймаг Шарын гол сум Монмаг ХХК-н агуулах**

| № | Тэсрэх материалын нэр | Марк | Хэмжих нэгж | Нийт хэмжээ | | Олгох агуулах |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | Үсгээр | |
| 1 | Анфо | савлагаатай | кг | 5200 | таван мянга хоёр зуу | Монмаг ХХК |
| 2 | Өдөөгч | 500 гр | ш | 62 | жаран хоёр | Монмаг ХХК |
| 3 | Цахилгаан бус тэслүүр /гадарга/ | искра | ш | 62 | жаран хоёр | Монмаг ХХК |
| 4 | Цахилгаан бус тэслүүр /цооног/ | 12м | ш | 62 | жаран хоёр | Монмаг ХХК |
| 5 | Цохилтын долгион дамжуулах гуурс /тэслүүртэй/ | искра | м | 500 | таван зуу | Монмаг ХХК |

Тэсрэх материалын тээвэрлэлтийг **МОНМАГ ХХК** гүйцэтгэнэ.

**Тээвэрлэх хуудас олгосон:**
Улсын ахлах байцаагч Ч.Мөнхсүрэн

**Тээвэрлэх хуудас авсан:**
Ти Эм Би Эн ХХК-н Тэсэлгээний менежер Н.Доржгарав

Олгосон огноо: 2025.07.01

*Зураг 16. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудас*

TMBN

**ИЛ УУРХАЙН ТЭСЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ПАСПОРТ**

**№**

Тэсэлгээний ажил явуулах газар: ___________“Си Би Зи” ХХК___________

_______Дархан-Уул аймаг Хонгор сум Асгат уул ил уурхай_______

Тэсэлгээ явуулах хугацаа: ________________2025 – 07 – 03 ____________

Тэсэлгээний ажил явуулах дэвсгэр нутгийн аюулгүй байдлыг хариуцагч /Захиалагч/:

| Уурхайн дарга | Р. Энхбат | [signature] |
|---|---|---|
| *албан тушаал* | *овог нэр* | *гарын үсэг* |

Тэсэлгээний ажлыг хариуцан явуулагч / Тэсэлгээний ажлын удирдагч /:

| Т. Менежер | Н. Доржгарав | [signature] |
|---|---|---|
| *албан тушаал* | *овог нэр* | *гарын үсэг* |

Тэсэлгээнд бэлтгэх, тэсэлгээ хийх, тэсэлгээний дараах аюулыг устгахад оролцох ажилчид:

| *Албан тушаал* | *Овог нэр* | *Гарын үсэг* |
|---|---|---|
| Тэсэлгээчин | С. Ганзориг | [signature] |
| Тэсэлгээчин | Э. Гантөмөр | [signature] |
| ТМ Боорч | Б. Ганхуяг | [signature] |
| | | |
| | | |
| | | |
| | | |
| | | |
| | | |
| | | |

**Тэсэлгээний ажил гүйцэтгэлийн дүгнэлт**

Тэсэлгээний ажил хэвийн болсон ямар нэгэн зөрчил гараагүй.

Тэсэлгээний паспорт боловсруулсан :.......[signature]....... / Н.Доржгарав /

*Зураг 17. Ил уурхайн тэсэлгээний ажлын пасспорт*

# НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| Болзошгүй сөрөг нөлөөлөл | Нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Зардал, мян.төг | Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал |
|---|---|---|---|
| Хог хаягдлын цэг, ангилан ялгах үйлдвэрийн талбай, кемп орчимд бохирдол үүсгэж болзошгүй | Хог хаягдлыг ялгах, зайлуулах, устгах, цэвэршүүлэх менежментийн төлөвлөгөөг мөрдөн ажиллах | **1 000.0** | Хог хаягдлыг нэгдсэн цэгт төвлөрүүлж, хог хаягдлын гэрээний дагуу сар бүр тогтмол тээвэрлүүлж байсан. |
| Нийт | | **1 000.0** | |

Хог хаягдлын гэрээг Хонгор сумын “Хонгор хот тохижилт” ОНӨААТҮГ-тай байгуулж, гэрээний дагуу хог хаягдал тээвэрлүүлсний зардал 960 000.0 төгрөгийг тушаасан. /Хог хаягдлын гэрээ, санхүүгийн баримтыг хавсаргав./

Огноо/Date:2025.05.30 14:55:32

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын/Journal No:29278665

Системийн огноо/System Date:2025.05.30 14:55:32

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт/From | IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number 5086046007 | Нэр/Name B****Я МӨНХТУЯА | Дүн/Amount 960,000.00 MNT | Ханш/Rate 1.00 |
| / Есөн зуун жаран мянган төгрөг / | | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No 05 IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number 5054187159 | Банкны нэр/Bank Name Khan Bank - Хаан банк Нэр/Name ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН ХОНГОР ХОТ ТОХИЖИЛТ | 960,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
Си Би Зи ХХК-с хог хаягдалын төлбөр 2076624

***Зураг 18. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт***

БАТЛАВ:
Хонгор сумын "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ-ын дарга
............/Д. Ариунболд/

БАТЛАВ:
Си Би Зи ХХК
-н Захирал
Б. Мөнхтуяа /Б.Мөнхтуяа/

**АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ**

2025 оны 5 сарын 19-ны өдөр №49 Хонгор сум

Энэхүү гэрээг нэг талаас хуулийн этгээдийн 279902 улсын бүртгэлийн дугаар 4293754 регистрийн дугаартай Дархан- Уул аймаг Хонгор сум "Хонгор Хот Тохижилт" ОНӨААТҮГ (цаашид үйлчлэгч ) тал гэх түүнийг төлөөлж Хог хаягдлын үйлчилгээний зохион байгуулагч Гансүх овогтой Нарантуяа нөгөө талаас хуулийн этгээдийн 1911013037 улсын бүртгэлийн дугаар 2076624 регистрийн дугаартай Си Би Зи ХХК-г түүнийг төлөөлж Болоод захирал Албан тушаалтай Болоод овогтой Мөнхтуяа (цаашид " Үйлчлүүлэгч") тал гэх нар Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж дүрэм журмыг удирдлага болгон дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

**Нэг: Гэрээний ерөнхий нөхцөл**

1.1. Дархан-Уул аймаг Хонгор сумын "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ нь Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булж устгах тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагааны үндсэн чиглэл, хог хаягдлыг тухай хуулийн хүрээнд захиалагч Сард төгрөг 80.000-н өдөр тутмын ахуйн хог хаягдлыг хувиарын дагуу татан зайлуулах

1.2. Захиалагч тал хогоо тээвэрлүүлэхээр дуудлага өгсөн тохиолдолд "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ зориулалтын тээврийн хэрэгслээр захиалагчийн хог хаягдлыг татан зайлуулах.

1.3. Гэрээг 3 жилийн хугацаатай байгуулж сунгалт хийх , нэмэлт өөрчлөлт оруулах зарчмаар хэрэгжүүлэх ба хоёр тал тус бүр нэг хувийг хадгална.

**Хоёр: Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг.**

2.1. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булж устгах эрх бүхий "Хонгор Хот Тохижилт" ОНӨААТҮГ-тай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах;

2.2. Шаардлага хангасан хогийн савтай байх, хог хаягдлыг ачих нөхцөл боломжоор хангасан байх

2.3. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд Хонгор сумын "Хонгор Хот Тохижилт" ОНӨААТҮГ-ын Хаан банкны **5054187159** тоот дансанд төлөх.

2.4. Нийтийг хамарсан цэвэрлэгээ, зохион байгуулалттай үйл ажиллагаанд

*Зураг 19. Хог хаягдал ачиж тээвэрлэх, хамтран ажиллах гэрээ*

хариуцлагатайгаар оролцох;

2.5. Байгууллагын орчны 50м дахь нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөс, хог ургамлыг цэвэрлэх,аюулгүй байдлыг хангах

2.6. Өдөр тутмын ахуйн хог хаягдлаас гадна Барилга барих, буулгах, засварлах гэх мэт .... үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг "Хонгор Хот Тохижилт" ОНӨААТҮГ-д захиалга өгч дуудлагаар үйлчлүүлж, үйлчилгээний хураамжийг төлөх;

2.7. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж сурах

2.8. Хог хаягдлын үйлчилгээний ажилтан алба хаагчдын тавьсан шаардлага хүсэлтийг биелүүлж хүндэтгэлтэй харьцах, дэмжих

**3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараах үйл ажиллагаа хориглоно:**

3.1. Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях;

3.2. Нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан суваг хог хаягдал хаях;

3.3. Хог хаягдлыг ил задгай шатаах;

3.4. Хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях;

**Дөрөв : Үйлчлэгч талыг эрх, үүрэг.**

4.1. Хог, хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, төвлөрсөн цэгт булж устгах ажлыг зохион байгуулах

4.2. Гэрээ болон бусад хууль тогтоомжийн дагуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, төвлөрсөн хогийн цэгт хаях, булж устгах үйлчилгээ үзүүлсний хураамж авч хуулийн дагуу сумын төрийн санд төвлөрүүлэх

4.3. Хууль тогтоомж, гэрээний үүргийн биелэлтийн талаар үйлчлүүлэгчид шаардлага тавих,

4.4. Хогоо татан зайлуулах захиалга хүлээж авснаас ажлын 2-5 хоногт багтаан үйлчлүүлэгчийн хог хаягдлыг татан зайлуулах

4.5. Сумын ИТХ-ын 2023 оны 04сарын 17 өдрийн 17-р тогтоолын хавсралтын үнэ тарифыг мөрдөнө. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг /тогтмол жилээр, тогтмол сараар, рейсээр , мкуб-аар / ангилал, төрөл, хугацаа, зайнаас/ хамааруулан тогтоодог

**Тав: Хариуцлага.**

4.1. Монгол Улсын Хог хаягдлын тухай хуулийн 43 дугаар зүйлийг зөрчсөн иргэн, айл өрх, ААН-ийг хог хаягдлын тухай хууль болон зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооно.

*Зураг 20. Хог хаягдал ачиж тээвэрлэх, хамтран ажиллах гэрээ*

4.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож, төлөх үнийн дүнд 0.5 хувиар алданги тооцон төлүүлэх

**Зургаа: Гэрээ байгуулсан.**

| Хонгор Сумын "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ-ыг төлөөлж | Аж ахуй нэгжийг төлөөлж |
|---|---|
| ------------------------------ | .................................................. |
| /Г.Нарантуяа/ | ------------------------------ |
| / ............................. / | ---------------/ / |
| Утас : 99372324 | Утас: 99053180 |

Сунгалт буюу нэмэлт өөрчлөлт

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

..............................................................................................

**Зургаа: Гэрээ байгуулсан.**

| Хонгор Сумын "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ-ыг төлөөлж | Аж ахуй нэгжийг төлөөлж |
|---|---|
| ------------------------------ | .................................................. |
| /Г.Нарантуяа/ | ------------------------------ |
| / ............................. / | ---------------/ / |
| Утас : 99372324 | Утас: .............................. |

Сунгалт буюу нэмэлт өөрчлөлт

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

..............................................................................................

**Зургаа: Гэрээ байгуулсан.**

| Хонгор Сумын "Хонгор хот тохижилт" ОНӨААТҮГ-ыг төлөөлж | Аж ахуй нэгжийг төлөөлж |
|---|---|
| ------------------------------ | .................................................. |
| /Г.Нарантуяа/ | ------------------------------ |
| / ............................. / | ---------------/ / |
| Утас : 99372324 | Утас: .............................. |

***Зураг 21. Хог хаягдал ачиж тээвэрлэх, хамтран ажиллах гэрээ***

# ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

ОХШХ-ийн хүрээнд агаар, ус, хөрсний шинжилгээг холбогдох лабораторид хийлгэсэн.

Агаарын бохирдлын шинжилгээг Дархан-Уул аймгийн УЦУОШТ-ийн байгаль орчны шинжилгээний лабораториор хийлгэсэн бөгөөд тус шинжилгээний дүнгээр агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосны агууламж агаарын чанарын MNS4585:2016 стандартын 1 удаагийн сорьцын дундаж хүлцэх агууламжаас давсан бохирдолгүй байв.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Дархан сум, 5 дугаар баг.УЦУОШТ-ийн байр
Утас: 7037-3783, 70374161
E-mail: darkhan-tsaguur@yahoo.com

УЦУОШТ

ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН

Дугаар он/№ : 2025/1-42
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “СИ БИ ЗИ” ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Г.Анхмаа, БОШЛ-ийн ахлах шинжээч
Сорьцын тоо, төрөл : 2-цэг, агаарын бохирдлын шинжилгээ
Сорьц авсан огноо : 2025.09.04
Шинжилсэн огноо : 2025.09.05
Хуудасны тоо : 1/2

| № | Шинжилгээний аргачлал | Агаарын шинжилгээний үзүүлэлт | Хэмжих нэгж | MNS4585: 2025 1 удаагийн сорьцын ХА | Хэмжилт хийсэн цэг 20 минутын сорьцын дундаж агууламж /давтамж | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1052250901 | 1052250902 |
| 1 | MNS 0017-2-5-12:2021 | Хүхэрлэг хий /SO2/ | мкг/м³ | 450 | 10 | 9 |
| 2 | MNS 0017-2-5-11:2021 | Азотын давхар исэл /NO2/ | мкг/м³ | 200 | 34 | 26 |
| 3 | MNS4048-88 | Нийт тоосонцор /20 мин/ | мкг/м³ | 500 | 182 | 95 |

Товчилсон үг: ХА-Хүлцэх агууламж
Сорьцын код: 1052250901- Үйлдвэрлэлийн орчин
1052250902- Үйлдвэрлэлээс 100 метрт гадаад орчин

Тайлбар:
1) Тухайн сорьц авах, хэмжилт хийх хугацааны цаг агаарын нөхцөл: Агаарын чийгшил 57-58%, агаарын температур 15.0-15.8 градус дулаан, салхи баруун хойноос 1-2 м/с хурдтай байсан.
2) Агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосны агууламж агаарын чанарын MNS4585:2025 стандартын 1 удаагийн сорьцын дундаж хүлцэх агууламжаас давсан бохирдолгүй байна.

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:
БОШЛ-ИЙН АГААРЫН ШИНЖЭЭЧ Ө.АЛТАНЗУЛ
ХЯНАСАН:
БОШЛ-ИЙН ХЯНАЛТЫН ШИНЖЭЭЧ Э.САЙНЗАЯА
БАТАЛГААЖУУЛСАН:
УОШХ-ИЙН ДАРГА М.АЛИМАА

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна

*Зураг 22. Агаарын чанарын шинжилгээний хариу*

Хөрсний шинжилгээг 9-р сард уурхай орчим дахь эрүүл талбайн өнгөн хөрснөөс дээж авч, Дархан-Уул аймгийн УЦУОШТ-ийн лабораторид шинжлүүлсэн. Тус шинжилгээгээр хөрсөн дэх хүнд металлын хэмжээ нь MNS3297:2019 стандартыг давсан үзүүлэлт байхгүй буюу хүнд металлын бохирдолгүй гэсэн үзүүлэлттэй байна.

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН**
**УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ**
**БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ**
**ЛАБОРАТОРИ**

Дархан сум. 5 дугаар баг.УЦУОШТ-ийн байр
Утас: 7037-3783, 70374161
E-mail: darkhan-tsaguur@yahoo.com

**ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН**

| | |
|---|---|
| Дугаар он/№ | : 2025/3-35 |
| Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : **“СИ БИ ЗИ” ХХК** |
| Сорьц авсан хүний нэр, албан тушаал | : Ө.Алтанзул, БОШЛ-ийн усны химийн ахлах инженер |
| Сорьцын тоо, төрөл | : 2 цэг, хөрсний химийн шинжилгээ |
| Сорьц авсан огноо | : 2025.09.04 |
| Шинжилсэн огноо | : 2025.09.10-19 |
| Хуудасны тоо | : 3/2 |

| № | Шинжилгээний аргын стандарт | Хөрсний химийн шинжилгээний үзүүлэлт | Хэмжих нэгж | MNS 3297:2019 ЗДХ | Тодорхойлсон агууламж | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 3052250901 | 3052250902 |
| 1 | MNS3310:91 | Хөрсний ялзмаг | % | | 0.78 | 1.27 |
| 2 | | Нитрат, $NO_3$ | мг/кг | 130 | 6.2 | 4.8 |
| 3 | | Сульфат, $SO_4$ | мг/кг | 160 | 33.9 | 26.5 |
| 4 | | Аммони, $NH_4$ | мг/кг | | 28.2 | 23.7 |
| 5 | | Фосфор, $P_2O_5$ | мг/кг | | 4.3 | 3.0 |
| 6 | | PH | | | 6.72 | 7.11 |
| 7 | | EC | µS/cm | | 375.0 | 408.0 |

Товчилсон үг: ЗДХ - зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Дээжийн код: 3052250901- Үйлдвэрийн орчин
3052250902- Үйлдвэрийн орчноос 100м зайд

Тайлбар:
1) Хөрсний дээжийг диагоналийн арга ашиглан авч анхан шатны боловсруулт хийн шинжилгээний ажилд бэлтгэсэн.
2) Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS3297:2019 стандарт дахь хөрсний эрүүл ахуйн шаардлагын химийн үзүүлэлтээр нитрат /$NO_3$/, сульфат /$SO_4$/-ын агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан бохирдолгүй.

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:
БОШЛ-ИЙН АГААРЫН ХИМИЙН АХЛАХ ИНЖЕНЕР ГАНХМАА
ХЯНАН, БАТАЛГААЖУУЛСАН:
БОШЛ-ИЙН ХИМИЙН ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕР Э.САЙНЗАЯА

УС ЦАГ УУР ОРЧНЫ ... БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна

Scanned with CamScanner

*Зураг 23. Хөрсний шинжилгээний хариу*

Манай компани нь унд ахуйн хэрэглээний усыг “Дархан-Ус суваг” ХК-аас зөөврөөр авдаг бөгөөд тус үйлдвэрийн төвийн шугамны усыг “Дархан-Уул аймгийн УЦУОШТ-ийн лабораторид өгч шинжлүүлсэн болно.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЛАБОРАТОРИ

Дархан сум. 5 дугаар баг.УЦУОШТ-ийн байр
Утас: 7037-3783, 70374161
E-mail: darkhan-tsaguur@yahoo.com

**ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН**

Дугаар он/№ : 2025/2-29
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “СИЛИКАТ” ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Ө.Алтанзул, БОШЛ-ийн усны химийн ахлах инженер
Сорьцын тоо, төрөл : 1 цэг, усны химийн шинжилгээ
Сорьц авсан огноо : 2025.09.05
Шинжилсэн огноо : 2025.09.08-18
Хуудасны тоо : 2/3

| № | Шинжилгээний аргачлал | Усны химийн шинжилгээний үзүүлэлт | Хэмжих нэгж | MNS 0900:2018 ЗДХ | Агууламж 2058250901 |
|---|---|---|---|---|---|
| 1 | MNS1097:2023 | $Ca^{+}$ /кальци/ | мг/л | 100.0 | 30.5 |
| 2 | MNS1097:2023 | $Mg^{+}$ /магни/ | мг/л | 30.0 | 25.8 |
| 3 | MNS1097:2023 | $Na^{+}+K^{+}$ /натри кали/ | мг/л | 200.0 | 31.5 |
| 4 | MNS6832:2020 | $HCO_3^-$ /гидрокарбонат/ | мг/л | | 207.0 |
| 5 | MNS 6271:2011 | $SO_4^{-}$ /сульфат/ | мг/л | 500.0 | 45.3 |
| 6 | MNS4424:2005 | $Cl^-$ /хлорид/ | мг/л | 350.0 | 6.1 |
| 7 | MNS1097:2023 | Нийт эрдэсжилт | мг/л | | 353.2 |
| 8 | MNS6836:2020 | Жинлэгдэх бодис | мг/л | | 1.32 |
| 9 | MNS6779:2019 | Хатуулаг /Ca Mg/ | мг-экв/л | 7.0 | 5.25 |
| 10 | MN ISO 7150-1:2006 | $NH_4$ /аммони/ | мгN/л | 1.5 | 0.07 |
| 11 | MNS6779:2019 | $NO_2$ /нитрит/ | мгN/л | 1.0 | 0.001 |
| 12 | MNS6834:2020 | $NO_3$ /нитрат/ | мгN/л | 50.0 | 0.37 |
| 13 | MN ISO 6878:2001 | Рэрд /ортофосфат/ | мгР/л | | 0.030 |
| 14 | MNS 6272:2011 | F /фтор/ | мг/л | 0.7-1.5 | 0.28 |
| 15 | MNS 4430:2005 | Fe /төмөр/ | мг/л | 0.30 | 0.019 |
| 16 | MNS ISO10523:2001 | PH /усны орчин/ | | 6.5-8.5 | 7.89 |
| 17 | MNS ISO7888:1999 | EC /ЦДЧ/ | µS/cm | | 397.0 |
| 18 | MNS ISO11083:2001 | Cr-VI /6 валентат хром/ | мг/л | | илрээгүй |
| 19 | MNS 6833:2020 | Перманганатын исэлдэх чанар | мг/л | | 1.1 |

Товчилсон үг:ЗДХ-зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Дээжийн код: 2058250901- ундны ус

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:
БОШЛ-ИЙН АГААРЫН ХИМИЙН АХЛАХ ИНЖЕЕР АНХМАА
ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:
БОШЛ-ИЙН ХИМИЙН ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕР Э.САЙНЗАРА

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна

*Зураг 24. Усны шинжилгээний хариу*


Төрийн Банк / State Bank

2025.10.14 17:27:45

ГЯЛС БАНК ИНТЕРНЭТ-ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ
/Gyals bank internet-transaction report

Системийн огноо / System date:
2025.10.14

Журналын № / Journal №:
941891395148

| | Дансны № / Account № | Нэр Овог / Name Surname | Мөнгөн дүн тоогоор / Amount | Ханш / Rate |
|---|---|---|---|---|
| Дт | MN870034140001875970 | СИ БИ ЗИ | 226,000.00 MNT | 1.00 |

Мөнгөн дүн үсгээр / Amount in words: / хоёр зуун хорин зургаан мянга-н төгрөг /

| | Банкны № / Bank № | Банкны нэр / Bank name | Мөнгөн дүн тоогоор / Amount | Ханш / Rate |
|---|---|---|---|---|
| Кт | 0090<br>Дансны № / Account №:<br>MN600090100190013015 | Төрийн сан<br>Нэр Овог / Name Surname<br>Дв.УЦУОШТөв | 226,000.00 MNT | 1.00 |

*Зураг 25. ОХШХ-ийн төлбөр төлсөн баримт*

## АРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 4. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| Нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал |
|---|---|
| Уурхайн бэлтгэл ажлыг бүрэн хангах | Уурхайн бэлтгэл ажлыг бүрэн хангаж, уурхайн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн, аюул осол эрсдэлгүй явуулах нөхцөлийг бүрдүүлсэн. |
| УАТөлөвлөгөө болон БОМТ-г боловсруулан батлуулах | УАТөлөвлөгөө болон БОМТ-г цаг хугацаанд нь боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулсан. |
| БОМТ-нд тусгасан ажлуудыг хэрэгжүүлэх | БОМТ-нд тусгагдсан нийт ажлуудыг уурхайн үйл ажиллагаандаа тусгаж, бүрэн хэрэгжүүлсэн. |
| Ажилчдыг ХХАА-ны хувцас хэрэгслээр бүрэн хангах | Ажиллагсдыг тоосноос хамгаалах хошуувч, хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан. |

Удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн Хонгор сумтай “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-г байгуулсан.

БАТЛАВ
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.ГАНБААТАР

СИ БИ ЗИ ХХК

БАТЛАВ
"СИ БИ ЗИ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ
В.МӨНХТУЯА

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2025 оны 06-р сарын 02 -ны өдөр №.... Буурал

Энэхүү гэрээг нэг талаас Дархан-Уул аймгийн Хонгор сумын Засаг даргыг төлөөлж, Засаг даргын орлогч Т.Нинжбадам /цаашид "Засаг даргын орлогч" гэх/, нөгөө талаас түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Си би зи" ХХК /РД:2076624/-ийг төлөөлж, захирал В.Мөнхтуяа /цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх/ нар /цаашид хамтад нь "Талууд" гэх/ дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Дархан-Уул аймаг Хонгор суманд байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү гэрээ нь Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ.

1.3. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй энэхүү гэрээг тухайн аймгийн Засаг даргатай байгуулна.

**Хоёр. Сумын Засаг даргын эрх, үүрэг**

**2.1 Энэхүү гэрээний хүрээнд сумын Засаг дарга дараах эрхийг хэрэгжүүлнэ.**

2.1.1 гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах;

2.1.2 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хяналт тавих;

2.1.3 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх;

*Зураг 26. Нийгмийн хариуцлагын гэрээ*

**2.2 Энэхүү гэрээний хүрээнд сумын Засаг даргын дараах үүргийг хэрэгжүүлнэ.**

2.2.1 хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;

2.2.2 энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж аймаг, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх,

2.2.3 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах,

**Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг**

**3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрхийг хэрэгжүүлнэ.**

3.1.1 үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;

**3.2 Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах үүргийг хэрэгжүүлнэ.**

3.2.1 орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэдний сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;

3.2.2 хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;

3.2.3 хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг, сумын иргэдэд тогтмол буюу улирал бүр мэдээлэл өгч байх;

3.2.4 бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид давуу эрх олгох;

3.2.5 сумын Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах;

3.2.6 Хонгор сумын нутагт тохижилт үйлчилгээний ажилд шаардагдах 18*36*60 харьцаатай 3000 ширхэг блокыг нийлүүлэх;

3.2.7 Тусгай зөвшөөрөл эзэмшигч "Си би зи" ХХК нь жил бүр 50-аас доошгүй ахмадад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2.8 Тусгай зөвшөөрөл эзэмшигч "Си би зи" ХХК нь шинэ жилийн баяраар 50-аас доошгүй хүүхдэд, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр 50 хүүхдэд тус тус дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2.9 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэдний мэргэжлийн сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтран ажиллах, ажлын байрны нээлттэй өдөрлөг зохион байгуулж, тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан иргэдийг ажлын байраар хангаж ажиллуулах;

3.2.10 Хууль тогтоомжийн дагуу байгалийн гэнэтийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийн хариу арга хэмжээний үед техник, хүн хүч, бусад бараа материалын дэмжлэг үзүүлж хамтран ажиллах;

*Зураг 27. Нийгмийн хариуцлагын гэрээ*

3.2.11 Сумын төв болон Салхит багийн төвлөрсөн холийн цэгийг түрш булшлах ажилд шаардлагатай тохиолдолд дэмжлэг үзүүлэх;

3.2.12 Өвөлжилт хүндрэлтэй үед ээрлэг амьтдад хоол тэжээлийн тусламж дэмжлэгийг шаардлагатай үед үзүүлэх;

3.2.13 Хонгор сумын Хонгор хот тохижилт ААТҮГазартай хогны гэрээг байгуулан хамтарч ажиллах;

**Дөрөв. Гэрээг дүгнэх ажлын хэсэг**

4.1. Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Засаг даргын шийдвэрээр байгуулж ажиллуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.2 Хууль заасны дагуу байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөллийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болно.

4.2. Ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэй (Засаг даргын орлогч, Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, Хөдөө аж ахуйн тасгийн дарга, тухайн байрших багийн Засаг дарга) байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна.

4.3. Ажлын хэсэг гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

**Тав. Гэрээг дүгнэх**

5.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ажлын хэсэгт жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гэрээний хэрэгжилтийг ирүүлнэ.

5.2 Ажлын хэсэгт ирүүлсэн гэрээний биелэлтийг уг гэрээний 5.3-т заасан аргачлалын дагуу жил бүрийн 02 дугаар сарын 20-ны дотор дүгнэж, гэрээ дүгнэсэн актыг 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ.

5.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээний хэрэгжилтийг /хавсралт-1/ маягтын дагуу дүгнэнэ.

| № | Гүйцэтгэлийн биелэлт /хувь/ | Үнэлгээ |
|---|---|---|
| 1 | 90-100 | Хангалттай сайн |
| 2 | 70-89 | Хангалттай |
| 3 | 70-аас доош | Хангалтгүй |

5.4 Дүгнэлтийн дагуу 70-аас доош буюу “Хангалтгүй” үнэлэгдсэн бол гэрээг цуцлах буюу хамтран ажиллах гэрээг дахин байгуулахгүй байх үндэслэл болно. 70-89 хувь буюу “Хангалттай” үнэлэгдсэн бол гэрээнд зааснаас бусад нэмэлт үүргийг хэрэгжүүлэхээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. 90-100 хувь буюу “Хангалттай сайн” үнэлэгдсэн бол гэрээг цаашид сунгаж, орон нутгийн зүгээс дэмжлэг, туслалцааг үзүүлэн ажиллана.

**Зургаа: Гэрээний хариуцлага**

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг гэрээнд заасан үүргийг зохих ёсоор биелүүлээгүй, хууль ёсны шаардлагыг удаа дараа биелүүлээгүй бол гэрээг цуцална.

*Зураг 28. Нийгмийн хариуцлагын гэрээ*

**Долоо: Маргаан шийдвэрлэх**

7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв дүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

**Найм: Гэрээ хүчин төгөлдөр болох**

8.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4. Гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ХОНГОР СУМЫГ ТӨЛӨӨЛЖ:**

ХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ ............ Т.НИНЖБАДАМ

**“СИ БИ ЗИ” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ЗАХИРАЛ ............ В.МӨНХТУЯА

*Зураг 29. Нийгмийн хариуцлагын гэрээ*

Уурхайн ажилчдад ХАБЭА-н мэдлэг олгох сургалтыг “Ойгон нөмрөг” ТББ-тай хамтран зохион байгуулсан. /Сургалтыг “Силикат” ХК-тай хамт авсан бөгөөд сургалтын төлбөрийг “Силикат” ХК-аас төлсөн болно./



ОЙГОН НӨМРӨГ ТББ
ХАБЭА-Н СУРГАЛТЫН ТӨВ

СЕРТИФИКАТ

НА25/25

**“СИЛИКАТ” ХК-д**

**Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн нийт ажилтны сургалтанд амжилттай хамрагдсан тул СЕРТИФИКАТ олгов.**

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР ______ М.ТӨМӨРХУЯГ

Дархан-Уул аймаг
2025 он



НА25/25 ***ТООТ СЕРТИФИКАТЫН ХАВСРАЛТ***

Байгууллагын нэр: **“СИЛИКАТ” ХК**
РД: 2050463

Үнэмлэх: 87
Огноо: 2025/04/03
Хичээлийн нийт цаг: 12

| *Хичээлийн сэдэв* | *Хичээлийн цаг* |
|---|---|
| 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ерөнхий ойлголт | 1 цаг |
| 2. Хөдөлмөрийн тухай хууль | 1 цаг |
| 3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль | 1 цаг |
| 4. Үйлдвэрлэлийн осолд хүргэдэг аюултай хүчин зүйлс, урьдчилан сэргийлэлт | 2 цаг |
| 5. Ажлын байран дахь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсийн төрлүүд, мэргэжлээс шалтгаалсан өвчин /МШӨ/ | 1 цаг |
| 6. Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн төрлүүд, зохистой хэрэглээ | 1 цаг |
| 7. Ажлын байран дахь осол, өвчлөл үүсгэж болзошгүй хүчин зүйлсийг таньж илрүүлэх, мэдээлэх, урьдчилан сэргийлэхэд ажилтны үүрэг, оролцоо | 1 цаг |
| 8. Ажил эхлүүлэхээс өмнө эрсдэлийн үнэлгээ хийх арга, практик дадлага | 1 цаг |
| 9. Онцгой байдалд хэрэгжүүлэх арга хэмжээ, гамшгийн бэлэн байдал | 1 цаг |
| 10. Осолд өртөгсөд үзүүлэх анхны тусламж | 1 цаг |
| 11. Ажилтны зан үйлтэй холбоотой өвчлөл, түүний урьдчилан сэргийлэлт | 1 цаг |
| 12. Шалгалт үнэлгээ | |

Сургалтын менежер:..........................Б.Оджаргал

*Зураг 30. ХАБЭА-н сургалтын сертификат*

ХААН БАНК

Огноо/Date: 2025-08-26 10:34:45

**Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information**

Журналын /Journal No: 38447726

Гүйлгээний дугаар /Poid: 1122506189

Системийн огноо/System Date: 2025-05-01 16:12:17

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт | IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card number<br>5086105463 | Нэр/Name<br>СИЛИКАТ | Дүн/Amount<br>1,950,000.00 MNT | Ханш/Rate<br>1.00 |
| Кт | Банкны дугаар/Branch No<br>CAXBMNUB<br>IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card Number<br>MN890032 005002342829 | Банкны нэр/Bank Name<br>ХАС БАНК<br>Нэр/Name<br>Ойгон Нөмрөг | 1,950,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-СИЛИКАТ ХК-С СУРГАЛТЫН ТӨЛБӨР 2050

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

***Зураг 31. ХАБЭА-н сургалтын төлбөр төлсөн баримт***




***Зураг 32. ХХАА-ны хувцас хэрэгслээр хангасан байдал***

ХААН БАНК

Огноо/Date: 2025-09-13 11:40:59

**Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information**

Журналын /Journal No: 32156774

Системийн огноо/System Date: 2025-09-12 16:48:35

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт | IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card number<br>5309286971 | Нэр/Name<br>ВОЛОДЯ МӨНХТУЯА | Дүн/Amount<br>986,400.00 MNT | Ханш/Rate<br>1.00 |
| Кт | Банкны дугаар/Branch No<br>050000<br>IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card Number<br>5011327406 | Банкны нэр/Bank Name<br>ХААН БАНК<br>Нэр/Name<br>НОЁН БААТАР БЯМБАЖАВ | 986,400.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:

1 А/гуталын үнэ

***Зураг 33. Ажилчдын хувцас хэрэгсэл худалдан авсан санхүүгийн баримт***

# АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулан БОУАӨЯ-ны цахим системд цаг хугацаанд нь илгээж, Дархан-Уул аймгийн БО-ны газарт хүргүүлсэн болно.

## ДҮГНЭЛТ

Манай компани нь 2025 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Тоосжилт ихтэй үед зам усалгааг тогтмол хийж байсан.
- ✓ Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших “Зулзагын голын ойжуулалт” хөтөлбөрт нэгдэж, 5.0 сая төгрөгийг шилжүүлсэн.
- ✓ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Зулзагын голын ойжуулалт” хөтөлбөрт нэгдэж, 5.0 сая.төг шилжүүлсэн.
- ✓ Уурхайн өрөмдлөг тэсэлгээний ажлыг мэргэжлийн гэрээт байгууллагаар гүйцэтгүүлж, осол авааргүй ажилласан. Уг ажилд 21.5 сая.төг зарцуулсан.
- ✓ Хог хаягдлын гэрээ байгуулж, гэрээний дагуу тээвэрлүүлж байсан. Уг ажилд 960.0 мян.төг зарцуулсан.
- ✓ Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан. Уг ажилд 986.4 мян.төг зарцуулсан.
- ✓ Уурхайн ажилчдыг ХАБЭА-н сургалтанд хамруулсан. Уг ажилд 1950.0 мян.төг зарцуулсан.
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаар, хөрс, усны шинжилгээ авч лабораторид шинжлүүлсэн. Уг ажилд 226.0 мян.төг зарцуулсан.
- ✓ Дархан-Уул аймгийн Хонгор сумтай “Нийгмийн хариуцлагын гэрээ” байгуулсан.

2025 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 12.5 сая.төг төлөвлөж, уг ажлуудыг хийж гүйцэтгэхэд 35.62 сая.төг зарцуулсан байна.